



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 29 өдөр

Дугаар А/166

Ховд

Хөрөнгө гаргах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн шагналын журам”-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн салбарт ард иргэдийнхээ эрүүл мэндийг сахин хамгаалах, хүн бүрийн эрүүл саруул, элэг бүтэн, аз жаргалтай амьдралын төлөө, эрдэм мэдлэгээ дайчлан, эрүүл энхийн манаанд зүтгэж буй аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн гэмтэл согог судлалын их эмч Б.Батбулган, эх барих эмэгтэйчүүдийн их эмч Х.Цэцэгсүрэн, нярайн их эмч Г.Насанбат, нярайн их эмч Г.Бадамжав, эх барих эмэгтэйчүүдийн их эмч Ж.Нямхишиг, эмгэг судлалын их эмч П.Ганбарс, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын албаны дарга Б.Оюунцэцэг, дотор, зүрх судасны тасгийн эрхлэгч эмч Б.Уранчимэг нарыг аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 240,000 төгрөг (хоёр зуун дөчин мянга)-ийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 240,000 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ